МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

ЗӨВ ЗҮГТ МАНЛАЙЛНА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2025

03-Р САР

www.mnca.mn

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

ОРШИЛ

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь өөрийн байгууллагын Эрхэм зорилго, зорилтын хүрээнд зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд нийцсэн барилгын салбарын тогтвортой байдлыг хангах, засаглалын зөв тогтолцоог бий болгох, салбарын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан урт, богино хугацааны бодлогын болон стратегийн бичиг баримтыг боловсруулахад нөлөөлөх, суурь судалгааг хийх, салбарын чадавхыг сайжруулах чиглэлд салбарын яам, холбоод, иргэний нийгэм, гадаадын төсөл, хөтөлбөр болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон талаар хамтран ажилладаг билээ.

Дээрх эрхэм зорилго, зорилтын хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2025 оны 03 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үйл ажиллагааныхаа тайланг товхимол хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ТАЙЛАН

2025

АГУУЛГА



1. ЗАХИРГАА УДИРДЛАГА
2. БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА
3. СУРГАЛТ, ХӨГЖИЛ
4. ГИШҮҮНЧЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА
5. БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
6. ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ-2

2025



ЗАХИРГАА-УДИРДЛАГА

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн реалтор, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 160 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг салбарын мэргэжлийн, манлайлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болох төрийн бус байгууллага юм. МБҮА ТББ нь Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбоо (FIDIC)-ны “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ын УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН” байгууллага юм.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫГ ЦАГААН САРЫН БАЯРЫН ЗОЛГОЛТЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА БОЛЛОО



МБҮА ТББ НЬ ХБХБОСЯ-тай хамтран БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ-ийн ийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулгыг 2025.03.10-ны өдөр зохион байгууллаа.

ХБХБОСЯ-ны Барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батзориг, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн танилцуулга ХБХБОСЯ-ны Орон сууцны хэлтсийн дарга Э. Батболд нар нь барилгын салбарын хууль эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал,

эрх зүйн орчныг хэрхэн шинэчлэх тал дээр хуулийн төслүүдийг салбарын мэргэжлийн холбоо болох МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болоод Удирдах зөвлөлийн гишүүд, гишүүдэд танилцуулж тэдний санал бодлыг тусгах тал дээр хамтран ажиллахаа илэрхийллээ.
Нийслэлийн төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүсүүдийг хөгжүүлэх, иргэдийн орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой орон сууцны төслүүдийг үргэлжлүүлэх, бодлогоор хангахад хууль эрх зүйн шинэчлэл зайлшгүй шаардагдаж буй энэ хувьд эрх зүйн бичиг баримтуудад хувийн хэвшлийн саналыг тусгах, хуулийн цоорхой гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар талууд сэтгэгдлээ хуваалцлаа.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛЛАА



Эдийн засаг хөгжлийн яам, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ, Азийн хөгжлийн банктай хамтран “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум”-ыг зохион байгуулж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрхзүйн орчны талаар хэлэлцэж, түншлэлээр хэрэгжих боломжтой төслүүдийг танилцууллаа.
Уг арга хэмжээний үеэр Нийслэлийн зүгээс хийгдэх төслүүдээс ойрын үед тендер нь зарлагдсан, ТЭЗҮ нь хийгдэж буй орон сууцжуулалтын төслүүдийг та бүхэндээ хүргэж байна.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БАГИЙНХАНТАЙ МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГА УУЛЗАЖ САНАЛ СОЛИЛЦЛОО



ЖАЙКА-Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага, СЯ, ЭЗХЯ, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын хамтран хэрэгжүүлэх Техникийн хамтын ажиллагааны “Улсын хөрөнгө оруулалтыг зохистой удирдах замаар болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх хүрээнд төслийн багийнхантай МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх гишүүдийн хамт уулзаж санал солилцлоо.

Улсын төсөвт дарамт учруулах магадлалтай төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн төрийн болон хувийн хэвшлийн түншлэгчийн эрсдэлийг оновчтой тодорхойлон үнэлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг төсөв, санхүүгийн удирдлагад тусгах, улсын хөрөнгө оруулалтын удирдлагаар дамжуулан хувийн хэвшлийн оролцоог дэмжих орчныг бүрдүүлэх зорилготой юм.

Төслийн хүрээнд Төр, хувийн хэвшлийн тухай хууль болон дагалдах дүрэм журмын дагуу хэрэгжих ТХХТ-ийн төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгон шалгаруулах, улмаар болзошгүй өр төлбөрийн талаас үүсэх эрсдэл талаас нь зөвлөмж өгөхөөс гадна, тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах холбогдох хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн гадаад болон дотоодын богино хугацааны сургалтыг зохион байгуулах юм байна.

“ЗӨӨЛӨН ХОТ”-ЫГ ТӨЛӨВЛӨХ ХҮРЭЭНД ДЭЛХИЙН НЭРТ ТӨЛӨВЛӨГЧ ДЭВИД СИМ МОНГОЛД АЙЛЧИЛНА



Дани улсын архитектор, хүнд эзэлтэй хот төлөвлөлтийн дэлхийн нэрт мэргэжилтэн Ян Гейлийн (Jan Gehl) шавь дэлхийн олон том хотуудын төлөвлөгчөөр ажилласан нэрт архитектор Дэвид Сим ирэх 2025.04 сард Монгол Улсад айлчилж "ЗӨӨЛӨН ХОТ" сэдвээр хот төлөвлөлтийн мэргэжилтнүүд, төсөл хөгжүүлэгчид төдийгүй иргэдэд туршлага, мэдлэгээсээ хуваалцаж, лекц уншин, нэг өдрийн хот төлөвлөлтийн фестивальд оролцох гэж байна.

Дэвид Симийн бичсэн "ЗӨӨЛӨН ХОТ" номыг Монгол Улсад анх удаа орчуулан гаргаж байгаа П.Мөнгөнчимэг (Берлин хотын ТИС ийн Хот болон бүс нутаг төлөвлөлтийн диплом инженер), болоод, тус номын багийнхан уг арга хэмжээг зохион байгуулах гэж байгаа бөгөөд 20 минутын хот Үндэсний хорооны зөвлөх Ph.D Б.Батболд тэргүүтэй төлөвлөгчид, зөвлөхүүд дэмжин оролцох юм.

Хот төлөвлөлтийн алдаа гажуудлыг зөвхөн төрийн байгууллагуудын буруутай үйл ажиллагаанаас болсон гэж холбохоос гадна төсөл хэрэгжүүлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын хандлага, мэдлэг туршлагатай холбохоос өөр аргагүй юм.
Иймд хүнд ээлтэй "ЗӨӨЛӨН ХОТ"-ыг хэрхэн төлөвлөх, хот төлөвлөлтийн баримжаатай барилгын төслийг хэрхэн амжилттай хийж болох талаар сонирхолтой мэдээлэл өгөх уг арга хэмжээнд мэргэжлийн архитекторууд, төлөвлөгчид, зураг төслийнхөн, төсөл хэрэгжүүлэгчид, ард иргэд хүрэлцэн ирж мэдээлэл аваарай.

ЕРӨНХИЙЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ БОЛЛОО





МБҮА ТББ-ын ээлжит сонгуулийн жил болж буйтай холбогдуулан Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурлыг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Дэд ерөнхийлөгч С.Нямдаваа, Б.Хүрэлхүү, Л.Ариунболд, Б.Чимэгцэцэг, Ц.Баяраа, Д.Энхтөр болон Гүйцэтгэх захирал Г.Батсүх нарын бүрэлдэхүүнтэй 2025.03.27-ны өдөр хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.
Хурлаар: МБҮА ТББ-ын Бүх гишүүдийн чуулганы хөтөлбөр, бэлтгэл ажлын төлөвлөгөө, Барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудыг эрэмбэлэх журмын төсөл, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим системийн өнөөгийн байдал, шинэчлэл, “Барилгын салбарын хөрөнгө оруулагчдын чуулган-2025” арга хэмжээний тов, урьдчилсан хөтөлбөр, Аймаг, орон нутагт МБҮА ТББ-ын салбар зөвлөл байгуулах, салбарын төрийн бус байгууллагуудыг гишүүнээр элсүүлэх, МБҮА ТББ-ын Дүрэм-ийн шинэчлэлийн талаар тус тус танилцуулж тодорхой шийдвэрүүдийг гаргалаа.

2025



САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

Салбарын бодлого, байгууллагын хөгжил:

ОРОН СУУЦНЫ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУС ЗОРИУЛАЛТТАЙ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬ ӨРГӨН БАРИГДАХТАЙ ХОЛБОГДУУЛАН УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



ОРОН СУУЦНЫ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУС ЗОРИУЛАЛТТАЙ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг боловсруулж, өргөн барихтай холбогдуулан тус хуулийг санаачлагч УИХ-ын гишүүн О.Номинчимэгтэй МБҮА-ийн Дэд ерөнхийлөгч Б.Хүрэлхүү, УЗ-ийн гишүүн Тесо пропертисс ХХК-ийн төлөөлөл болон МБҮА ТББ-ын Ажлын албаны Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар нар уулзалт хийлээ.

Уулзалтаар тус хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага, хуулийн төсөлд баримталж буй байр суурь, үзэл баримтлалын талаар танилцуулж улмаар хуулийн төслийг боловсруулах олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлгийг зохион байгуулахад МБҮА ТББ-ын зүгээс Гишүүн байгууллагуудынхаа оролцоог хангах, саналыг тусгах, хуулийн төслийн “Ажлын хэсэг”-т орж ажиллах тал дээр ойлголцолд хүрлээ.

Мөн МБҮА-ийн Ажлын албаны Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар тус Орон сууцны болон орон сууцны бус барилгын дундын өмчлөлийн менежментийн тухай хуулийн төслөөс гадна барилгын салбар дахь бусад хууль эрх зүйн орчны шинэчлэл Барилгын ерөнхий хууль, Орон сууцны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэрэг хуулийн төслүүд дээрх харилцан мэдээлэл солилцон хамтарч ажиллах хүсэлтээ илэрхийллээ.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГАД МБҮА ТББ САНАЛАА ТУСГАЛАА



Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ нь 2025.03.26-ны өдөр барилгын салбарынхантай хуулийн төслийг шинэчлэх хэрэгцээ шаардлага, байр суурь, үзэл баримтлалын талаар танилцуулж улмаар барилгын салбарын өсөлт нь компаниудын ашиг, хөгжлөөр хэмжигдэх ёсгүй бөгөөд байр орон сууц худалдан авч буй иргэдийн эрхийг хамгаалсан, тогтвортой, хариуцлагатай бодлого хэрэгтэй байгаа талаар санал бодлоо солилцлоо.

Барилгын тухай хуульд барилга байшин нь заавал зураг төсөлтэй баригдана, барилгын материал нь заавал тохирлын гэрчилгээтэй байна гэж заасан байдаг ч нөгөө талдаа 9 метр өндөртэй, 600м2 байшинг зураг төсөлгүйгээр барьж болно гэсэн журам байдаг нь хууль хоорондын үл ойлголцол гарч байна. Мөн барилгын материалыг эрсдэл багатай ангилалд багтаасан нь хил гаалиар чанар, стандартын шаардлага хангахгүй бараа материал орж ирэх нөхцөлийг бүрдүүлж улмаар иргэд, хэрэглэгчийн эрх ашгийг хохироох асуудал үүсэж байгаа талаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх онцолж, хуулийн төсөлд Гишүүдээсээ авсан саналыг хүргэлээ.
Уулзалтаар Хэрэглэгчийн эрх хэрхэн зөрчигдөж байна вэ? гэдэг дээр чанаргүй барилга, барилгын компаниудын хариуцлагагүй байдал, юугаар барьсан нь тодорхойгүй барилга байшинд ормогц ормогц хана, шал цуурах, дулаан алдах, сантехникийн доголдол, цахилгаан, лифт ажиллахгүй байх зэрэг асуудал гарч байгаа талаар хэлэлцэхээс гадна чиг үүргийн байгууллагуудын хяналтын тогтолцоо сул байгаа нь асуудал үүсгэж хуульд хэрхэн тусгаж оруулах тал дээр ойлголцолд хүрлээ.

- МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчийн 2025.02.25-ны өдрийн 25/01 дүгээр тушаалаар Барилгын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөлд өгөх нэгдсэн санал боловсруулах, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашдын чиг хандлагыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 4 удаагийн хурлыг зохион байгуулж холбогдох ажлуудыг хийж гүйцэтгээд байна.
- ХББОСЯ-тай хамтран Барилгын ерөнхий хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийн танилцуулгыг Ажлын хэсгийн гишүүддээ хүргэн улмаар Барилгын ерөнхий хуулийн үзэл баримтлалын төсөлд өгөх 9 зүйлийн саналыг боловсруулж ХББОСЯ-ны Ажлын хэсгийн хуралд биечлэн болон албан бичгээр тус тус холбогдох саналаа өгөөд байна.
- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл явцын өнөөгийн байдал, олон улсын жишиг туршлагуудын талаарх судалгааг Ажлын хэсгийн гишүүддээ танилцуулж, олон улсын жишиг туршлагаас өөрийн орон болоод байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх сайн туршлагын талаар ярилцаж, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цаашид хэрхэн сайжруулах талаар саналаа боловсруулж танилцуулах үүргийг Ажлын алба БҮАТЗ-ийн хэлтэст үүрэг болгосон.

Салбарын бодлого, байгууллагын хөгжил:

- Салбарын бодлого төлөвлөлтийн чиглэлээр Хот байгуулалтын салбарын тулгамдсан асуудал сэдвээр УИХ-ын гишүүн Лувсанжамцтай уулзалт хийж танилцуулга хийсэн.
- Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах, Барилгыг улсын комисст хүлээлгэн өгөхтэй холбоотой дүрмүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр ХББОСЯ, НЗДТГ-тай хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг хийхээр төлөвлөн холбогдох саналаа ХББОСЯ-д албан тоотоор хүргүүллээ.
- Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан 21 аймгуудын Газрын харилцаа, барилга хот байгуулалтын албаныханд онлайнаар Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийн төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сургалт хийж, байгууллагынхаа талаар мэдээ мэдээлэл өглөө.
- МБИХ ТББ-аас зохион байгуулсан УИХ-ын гишүүн Б.Хосбаяр, Ц.Мөнхбат нартай хийсэн уулзалтанд оролцож, Барилгын ерөнхий хууль, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгч ажиллаа.

- Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитр байгуулахтай холбоотой Легал клиник ЮПЭ ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэлээ.
- “Барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалтын чуулган 2025”-ыг зохион байгуулах Ажлын хэсгийг ахлан чуулганыг зохион байгуулах бэлтгэл төлөвлөгөө, чуулганы хөтөлбөрийн төсөл, төсөв зэргийг боловсруулан МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хуралд танилцуулсан.
- Барилгын компаниудыг эрэмбэлэх ажлын хүрээнд БНСУ, Япон, БНХАУ, ОХУ, ХБНГУ, Сингапур, Малайз гэсэн 7 улсын болон дэлхийн барилгын компаниудын эрэмбэлдэг Engineering News-Record (ENR) байгууллагын туршлага, мэдээллийг судлан орчуулж бэлтгэж, Барилгын компаниудыг эрэмбэлэх журам, эрэмбэлсэн жагсаалтын загвар, шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийг тооцох аргачлалын төсөл, ХББОСЯ руу явуулах албан бичгийн төсөл бэлтгэж бэлэн болгосон. Ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд танилцуулав.

Судалгааны ажлын чиглэлээр:

- МБҮА ТББ нь сар бүр салбарын мэдээлэл, судалгааны талаар "ИХ БАРИЛГА-ТООНЫ ХЭЛЭЭР" контентийг бэлдэж хүргэж байгаа бөгөөд энэ удаагийн дугаараар "БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧ-2024 " сэдвийн хүрээнд бэлтгэлээ.
- Албан ёсны статистикийн мэдээллээс 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын ажиллагчид, хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан Монгол иргэдийн тооны мэдээллийг цуглуулан авснаас гадна Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тайлан, Дэлхийн эдийн засгийн форумын "Ирээдүйн ажил мэргэжил 2025" тайлан, ХНХЯ-ны "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл: дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал 2024" тайланг татаж авч судалгаанд ашиглаж байна. Invescore property компаниас гаргасан Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн зах зээл тайланг татан авч байгаа мэдээллээ баяжуулсан.
- Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл бэлтгэн нийт гишүүдэд түгээлээ.
- Эксэл (excel) ашиглан бүс, аймаг, нийслэлийн өгөгдлийг газрын зургаар харуулж байна.

МОНГОЛЫН БАРИЛГЫН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО БАЙГУУЛАХААР САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД НЭГДЛЭЭ



Монгол Улсын Их Хурлаас 2024 онд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталж 2025.01.01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа билээ. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх хүрээнд барилгын салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах цаг үеийн шаардлага үүсэж улмаар салбарын мэргэжлийн холбоод нэгдсэн ойлголцолд хүрч барилгын салбарын ТББ-уудын Ерөнхийлөгчид “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурах арга хэмжээг 2025.03.26-ны өдөр МҮХАҮТ-ын байранд зохион байгууллаа. Барилгын салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулснаар дараах үр нөлөө гарах ба Үүнд:

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа олон төрийн бус байгууллагууд нэгдэж цар хүрээгээ тэлэх, олон улсад үйл ажиллагаа нь хүлээн зөвшөөрөгдөх, ур чадвар нэмэгдэх, улам мэргэших үндэслэл бий болох;

Барилгын салбарын бодлого, хөтөлбөр боловсруулалт болон төрийн байгууллагын шийдвэр гаргалтад санал өгөх, салбарын нийтлэг эрх ашгаа хамгаалах, мэргэжлийн байгууллагын үзүүлэх нөлөө нэмэгдэх;

Барилгын салбарт хамаарах төрийн зарим чиг үүргийг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу байгуулах гэрээний эсхүл хуулийн дагуу гүйцэтгэх нөхцөл бүрдэх;

Барилгын салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүрдэх, улам сайжрах;


Салбарт хамаарах асуудал төрийн байгууллагын хэт төвлөрсөн чиг үүргийг задалж, зарим чиг үүргийг илүү мэргэшсэн төвшинд гүйцэтгэх боломж бүрдэх;

Барилгын салбарын бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад оруулах хувь нэмэр, үр нөлөө нэмэгдэх.

Цаашид нэгдсэн холбооны дүрмийн төсөл боловсруулах болон холбоогоо бүртгүүлэх бэлтгэл хангах ажлуудыг холбоод хамтран хийх учир санамж бичиг зурах арга хэмжээний үеэр барилгын салбарын мэргэжлийн холбоод нэгдэж эхэлж байгаатай холбоотойгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бусад холбоодыг нэгдэхийг уриалсан уриалга гаргалаа.

Тус нэгдсэн холбоонд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо ТББ, Монголын Барилгын Инженер Геологичдын Холбоо ТББ, Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбоо ТББ, Өргөн Тээвэрлэх Машин Төхөөрөмж Үндэсний Холбоо ТББ, Монголын Бетоны Холбоо ТББ, Барилгын Ханган Нийлүүлэгчдийн Зөвлөл ТББ, Монголын Цонх Хаалга Үйлдвэрлэгчдийн Холбоо ТББ, Монголын Нийгэм Ахуйн Барилгын Холбоо ТББ, Монголын Инженерийн болон Зөвлөх Үйлчилгээний Үндэсний Холбоо ТББ, Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо ТББ, Хөгжлийн Төлөө Барилгачдын Нэгдэл ТББ-ууд нэгдлээ.

2025



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MCIS.GOV.MN

"БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЭЗЭМШИГЧДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САНАЛ ШИЙДЭЛ"-ИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ



УИХ-ын хаврын чуулганаар Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын тухай хууль өргөн баригдахтай холбогдуулан салбарын инженерүүд, төлөвлөгчид, төсөвчид, зураг төслийнхөн гээд бүхий л төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд хуульд өөрчлөлт оруулах саналуудаа нэгтгэх зорилгоор “БАРИЛГЫН САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” цуврал уулзалтуудыг хийж байгаа.

2025.03.22-ны өдрийн ээлжит уулзалтад "БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЭЗЭМШИГЧДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САНАЛ ШИЙДЭЛ"-Г МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар танилцууллаа. Мөн тус арга хэмжээний үеэр “Барилга байгууламжийн зураг төслийн үе шат, бүрдэл, зургийн даалгаврын өгөгдлийн аргачлал БД-н төслийн танилцуулга”-г МБИХолбооны Зөвлөх багийн гишүүн Г.Тулга, "Барилгын төсөвт өртгийн өнөөгийн байдал"-г МБИХолбооны Удирдах зөвлөлийн гишүүн М.Одмандах, "Тасралтгүй мэргэшил дээшлүүлэх сургалтын тогтолцоо, өнөөгийн байдал"-г МБИХолбооны Ерөнхийлөгч Б.Гантулга нар илтгэл тавьсан бол УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц болон УИХ-ын гишүүн П.Ганзориг нар хүрэлцэн ирж, барилгын салбарын тулгамдсан асуудал, хөгжлийн боломж, шийдлийн талаар мэргэжилтнүүдтэй санал солилцож хуульд өөрчлөлт оруулах саналуудыг хэрхэн тусган ажиллаж байгаа талаарх мэдээллийг өглөө.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ШИНЭ СУУРЬ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ТАЛААР ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮД САНАЛАА ХЭЛЖ БАЙНА.



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим программыг шинэчлэх, хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар ХБББОСЯ-тай 3 удаагийн уулзалт хийж, Санхүү мэдээллийн технологийн төв ТӨҮГ-ын удирдлагуудтай 3 удаагийн уулзалт хийхэд оролцож программ хангамжийн хөгжүүлэлт, шилжилттэй холбоотой асуудлаар санал өгсөн.
- Барилгын Хөгжлийн Төв ТӨҮГ-аас ирүүлсэн mcis.gov.mn барилгын салбарын мэдээллийн нэгдсэн сангийн программын ашиглалттай холбоотой гэрээний төсөлтэй танилцан тус гэрээтэй холбогдуулан Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын удирдлагуудтай уулзалт хийсэн.
- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардлагатай холбоотой асуудлаар Барилгын инженер геологчдын холбоо ТББ-аас ирүүлсэн албан бичигт хариу өгсөн.


БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ


БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 1000 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.





БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 315 ААНБ-ын хүсэлт, материалыг баталгаажуулж, ХБББОСЯ-нд 2025.03.06, 2025.03.13, 2025.03.20, 2025.03.27-ны өдрүүдэд тус тус цахимаар илгээв.





Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 836 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 34 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 315 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав.

Үүнээс: Сунгалтаар 5, Нэмэлтээр 81, Шинээр 228, Дахин олгохоор 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 5 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 5, Нэмэлтээр 81 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 63, Зураг төсөл боловсруулалтаар 17, Өргөх байгууламжаар 1, Шинээр 228 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 192, Зураг төсөл боловсруулалтаар 35, Өргөх байгууламжаар 1, Дахин олгохоор 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 4 удаагийн баталгаажуулалтаар давхардсан тоогоор 411 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, 141 ААНБ-ын хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.

- Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 315 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 1431 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 1 удаа ХБҺОСЯ-нд хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 4,363, ЗТ: 883, ӨБ: 156 ААНБ-ын нийт 5,402 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4,363, ЗТ: 883, ӨБ: 156 ААНБ-ын нийт 5,402 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 116, ЗТ: 24, ӨБ-1 ААНБ-ын мэдээллийг илгээв.
- ХБҺОС-ын Сайдын тушаалыг үндэслэн 138 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу

132,300,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.

- Үйлчилгээний хөлсний 315 ААНБ-ын 184,050,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.
- ХББОС-ын Сайдын 2025.03.17-ны өдрийн тушаал №55, №56 дугаар тушаалыг үндэслэн 141 ширхэг үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

2025

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ ОРОН НУТАГТ БАЙГУУЛЖ ЭХЭЛЛЭЭ





✅Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь өнгөрсөн 15 жилийн хугацаанд хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн гишүүд, салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож иржээ.

✅Барилгын бизнесийн орчныг сайжруулах, зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулах ажлыг манлайлан ажилласны үр дүнд энэ ажлыг ТББ- уудаар гүйцэтгүүлэх шийдвэрийг

Төр засгаар гаргуулан, 7 дахь жилдээ салбарын 6 холбоодтой хамтран амжилттай гүйцэтгэж байна.

✅Өнөөдрийн байдлаар уг үйл ажиллагаа бүрэн цахимжиж, тусгай зөвшөөрлийн журмыг хялбаршуулан ажлын 5-7 хоногт зөвшөөрлөө авдаг болсон байна.

✅Мөн бид гадаад харилцаагаа тогтмол өргөжүүлэн ажилласны үр дүнд Int'l Federation of Asian and Western Pacific Contractors' Associations Ази болон Баруун Номхон Далайн Орнуудын Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо, FIDIC -ийн Түншлэгч гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Үүний үр дүнд бид саяхан Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын эрхийг авч үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болж бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

✅Мөн бид Франц Улсын Жэрэс Монгол ОУТББ хамтран Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын айлуудын дулаан алдагдлыг бууруулахад мэргэшсэн технологийн сургалтаар дамжуулан бригадуудаар дулаалга хийлгүүлэх сургалт, дадлагад чадавхжуулах, нийслэлийн төлөвлөлтгүй бүсэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг барихад зөвлөгөөг өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээг үзүүлэх зорилготой төслийг хэрэгжүүлж байна.

Монголын барилгын салбарын хөгжилд зөв манлайлал үзүүлж ажиллана гэсэн уриатай ТББ -ын хувьд бид цаашдын үйл ажиллагаандаа дараах хэдэн чиглэлийн хамтын ажиллагааг онцгойлж байна. Дулаан шийдэл төсөл

✅ Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж салбар зөвлөл байгуулах ажлыг эхлүүллээ.

✅Тус ажлын хүрээнд 21 аймагт салбар зөвлөлийг байгуулж, орон нутгийн барилгын компаниуд, мэргэжилтнүүдийг нэгтгэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Салбар зөвлөлүүд нь тухайн аймаг, орон нутгийн барилгын компаниудын эрх ашгийг хамгаалах, барилгын салбарын хөгжлийг дэмжих, шинэ технологи, стандартыг нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах юм.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь салбар, зөвлөлүүдийнхээ үйл ажиллагааг идэвхжүүлж, салбарын хөгжлийг дэмжихэд дараах ажлуудыг төлөвлөж байна:

✍ Сургалт, зөвлөгөөн: Барилгын салбарын хууль, эрхзүй, стандартын талаарх мэдээллийг түгээх, орон нутгийн мэргэжилтнүүдийг сургах

✍ Туршлага солилцоо: Барилгын салбарын шилдэг компаниуд, мэргэжилтнүүдийг хамруулсан уулзалт, арга хэмжээ зохион байгуулах

✍Төслүүд, хөрөнгө оруулалт: Орон нутгийн барилгын салбарт хэрэгжих төслүүдийг дэмжих, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах

✍Шударга өрсөлдөөн, стандартын хяналт: Барилгын салбарт шударга өрсөлдөөнийг бий болгож, стандартын хэрэгжилтийг сайжруулах

Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтвортой явуулахын тулд МБҮА ТББ нь орон нутгийн төрийн байгууллагууд, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах бөгөөд салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь орон нутагт салбар зөвлөлийг байгуулах үйл ажиллагаанд орон нутгийн барилгын компаниуд, инженер, мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдийг идэвхтэй оролцож хамтран ажиллахыг урьж байна.

ХОВД АЙМГИЙН БАРИЛГЫН КОМПАНИЙН ТӨЛӨӨЛЛҮҮДТЭЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж салбар зөвлөл байгуулах ажлыг эхлүүллээ.

Тус ажлын хүрээнд 21 аймагт салбар зөвлөлийг байгуулж, орон нутгийн барилгын компаниуд, мэргэжилтнүүдийг нэгтгэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байгаа ба 2025.03.14-ны өдөр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Гишүүнчлэл хариуцсан менежерүүдийн хамт Ховд аймгийн барилгын салбарын төлөөллүүдтэй цаашид хэрхэн хамтрах ажиллах талаар санал солилцлоо.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь орон нутагт салбар зөвлөлийг байгуулах үйл ажиллагаанд орон нутгийн барилгын компаниуд, инженер, мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдийг идэвхтэй оролцож хамтран ажиллахыг урьж байна.

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2025 онд хэрэгжүүлэх Гишүүнчлэлийн мего төслийн хүрээнд гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2025.03-р сард Гишүүнээр барилга угсралт, барилгын материал худалдаа, үйлдвэрлэлийн ПРЕМИУМ МАЙНИНГ СЕРВИСЭС ХХК, НОМИН СТАНДАРТ ХХК, ИНЭЛ ХХК болон СИВИЛ ИНЖЕНЕРИНГ КОНСАЛТИНГ ХХК, ФЭЙРВИ ХХК Дэмжигч гишүүнээр элслээ. Мөн түүнчлэн шинээр нийт 6 байгууллага гишүүнээр элсэхээр гишүүнчлэлийн материал болон холбогдох хамтын ажиллагааны гэрээ байгууллахаар хүлээгдэж байна.

Барилгын салбарын ТББ-уудын судалгаа:

- УБЕГ-т бүртгэлтэй 144 ТББ-аас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 42 байгууллагыг судлав.Эдгээр байгууллагыг МБҮА-д элсүүлэх талаар Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хуралд танилцуулга хийв.



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ болон Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо Барилгын салбарын УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц Ганзоригийн Лувсанжамц-тай хамтарсан “БАРИЛГЫН САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” чөлөөт уулзалтыг 2025.03.22-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тус уулзалтад 30 гаруй инженер техникийн ажилтан болон ААНБ-уудын төлөөллүүд оролцон барилгын салбаруун тулгамдаж асуудлуудын талаар тэр дундаа барилгын салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй өнөөгийн байдал, чиг хандлагийн талаарх хэлэлцэн санал солилцох юм.

2025.03.27-ны өдөр МБҮА ТББ-ын 2025 оны Ерөнхийлөгчдийн зөвлөлийн II хуралдлаа. Тус хурлаар Ассоциацийн гишүүнчлэлийг нэмэгдүүлэх мега төсөл, төлөвлөгөө, 2024 оны нийт гишүүдийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт болон 2025 оны 03-р сарын байдлаар гишүүнчлэлийн тоо, татвар төлөвлөлтэй холбоотой мэдээллийг бэлдэн танилцуулан, холбогдох үүрэг даалгаварыг авав.




МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД ДУЛААНЫ СҮЛЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦЛАА




Нийслэл Улаанбаатар хотод томоохон бүтээн байгуулалт өрнөж буйтай холбогдуулан хотын ерөнхий төлөвлөгөөнд хаана, ямар дулааны эх үүсвэрүүдийг нэмэлтээр барих гэж байгаа болон БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН талаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх гишүүдийн хамт Улаанбаатар улааны сүлжээ ТӨХК-ийн дарга Ц.Амарсанаа болон тус байгууллагын удирдлагуудын хамт уулзалт хийж цаашид хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар тогтлоо.
Уулзалтаар Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн дарга Ц.Амарсанаа нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжийн өнөөгийн нөхцөл байдал, үнэ тариф, хаана нийслэл хотод дулаанд холбогдсон объектууд төв шугамын хүчин чадал, хаана ямар байршилд дулааны сүлжээ боломжтой байгаа талаарх мэдээллийг өглөө.
Харин барилгын компаниудын төлөөллүүдийг хүлээн авч өнөөгийн дулаан холболт, техникийн нөхцөл байдал, үнэ тарифын талаарх мэдээллийг өгсөнд талархаж байгаагаа дурдаж ирээдүйн бүтээн байгуулалтын төлөвлөгөөгөө хаана, хэрхэн яаж төлөвлөх талаарх санал бодлоо хуваалцлаа.

Байгууллагын үйл ажиллагаа, маркетинг олон нийтэд сурталчлах зорилгоор дараах постер эх дизайныг бэлтгэн хүргэв.







ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ БОЛЛОО

- МБҮА ТББ-аас өнөөдөр (2025.03.20) гишүүн байгууллагууд болон Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн дулаалгын зөвлөхүүдийнхээ дунд "Өглөөний ажил хэрэгч бизнесийн уулзалт" зохион байгууллаа. Барилгын салбарын бизнес эрхлэгчид харилцан туршлага солилцох, хамтран ажиллах боломжийг олгосон энэхүү уулзалтыг МБҮА ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Батсүх өглөөний эрч хүчтэй үгээр эхлүүлсэн.
- 40 гаруй хүн оролцсон энэхүү уулзалтын зочид болох “Гурван бухат групп” ХХК-ийн ерөнхий захирал Т.Ганчимэг, “Добу технологи” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Тулгабаатар нар бизнес эрхлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалт босгохоос эхлээд гүйцэтгэлдээ анхаарах, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөртөө мэдээллийн технологийн оновчтой шийдлүүд нэвтрүүлэх нь зүйтэй талаар хэлж байв.
- “Аливаа асуудал тулгарлаа гэхэд түүнийг бэрхшээл гэж харалгүй, гарц хайдаг. Хэлсэндээ хүрдэг байх нь хамгийн чухал" гэдгийг Т.Ганчимэг онцолж байсан бол “Сүүлийн үеийн технологийн чиг хандлага нь эрүүл амьдралын хэв маягт чиглэж байгаа” талаар Д.Тулгабаатар оролцогчдод мэдээлэл өглөө. Мөн уулзалтаар “Бульдорс Мон ХХК”, “Ультрасоник” ХХК, “Динамик тауэр” ХХК өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ онцлог, давуу талыг танилцуулав.
- Бульдорс Мон ХХК: ОХУ ГОСТ болон Европын EN стандартад нийцсэн хаалгануудыг өрсөлдөхүйц үнэ, төлбөрийн уян хатан нөхцөлөөр санал болгож, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна.
- Ультрасоник ХХК: Ногоон технологийг нэвтрүүлэгч бөгөөд ХБНГУ-ын Ландис+Гир фирмийн Монгол Улс дахь албан ёсны борлуулагчаар ажиллаж, орчин үеийн дулааны эрчим хүчний тоолуур оруулж ирж байна.
- Динамик тауэр ХХК: "Дэлхийн тэргүүлэгч технологийг Монголд" гэсэн концепциор зураг төсөл, төмөр хоолойн үйлдвэрлэл, галын утаанаас хамгаалах систем, халаалт, агаар сэлгэлт ба хөргөлтийн системийг нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.
- Уулзалтын төгсгөлд, МБҮА ТББ нь 2025 онд гишүүддээ зориулан, олон улсад зохион байгуулагдах барилгын салбарын шинэ техник, технологитой танилцах аялал, хүний нөөцийг чадавхжуулах сургалтууд, салбарын цаг үеийн асуудлуудыг хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлэг зэргийг тодорхой хуваарийн дагуу тогтмол зохион байгуулах бөгөөд 21 аймагт Ассоциацийн салбар зөвлөлийг байгуулж эхэлснээ Гишүүнчлэл хариуцсан менежер Х.Намуун танилцуулсан юм.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Хөрөнгө оруулалтын чуулган зохион байгуулах бэлтгэл ажил:

- Холбогдох маркетинг, зар сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулж, зорилго, зорилтыг тодорхойлж, санхүүжилтийн эх үүсвэрийг гаргав.
- Чуулган зохион байгуулах байршлын судалгаа хийж, холбогдох мэдээллийг нэгтгэв.
- 2025.03.27-нд болсон Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурлаар танилцуулга хийж 2025.09-р сард хийхээр товыг тогтоов.





Turkey Build 2025 үзэсгэлэнгийн бэлтгэл ажлын хүрээнд:

- IcaEvent байгууллагатай хамтран Турк улсын Истанбул хотноо зохион байгуулагдах "Turkey Build Istanbul-2025" үзэсгэлэнд оролцохоор болов.
- МБҮА-гийн гишүүн байгууллагуудад үзэсгэлэнгийн талаар мэдээлэл түгээж, маркетинг, идэвхжүүлэлтийн ажлуудыг эхлүүлэв.
- Үзэсгэлэнд нийт 20 байгууллага, төлөөлөгчдийг урьж оролцуулахаар төлөвлөв.



Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа:

- CHINCA байгууллагатай тогтмол холбоотой ажиллаж, Бээжинд уулзалт зохион байгуулах талаар мэйл бичсэн.
- CMEC Expo зохион байгуулагчтай холбогдож, 9-р сард хамтран Экспо зохион байгуулахаар төлөвлөв.
- Олон улсын байгууллагуудтай харилцаа тогтоож, Монголд хөрөнгө оруулах сонирхолтой түншүүдийг судлах ажлыг эхлүүлэв.

CMEC


2025


“ДУЛААН ШИЙДЭЛ2" ТӨСӨЛ



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.DULAALGA.MN


ШИНЭ DULAALGA.MN ВЕБ САЙТЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ТАЛААРХ СУРГАЛТЫГ ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДДЭЭ ОРЛОО





Dulaalga.mn шинэ веб систем ашиглалт, дулаалгын зөвлөхүүдийн зүгээс тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох сургалтыг цахим болон биет хэлбэрээр Мэдээллийн технологийн зөвлөх Мөнгөнзалаа “Дулаан шийдэл II” төслийн дулаалгын зөвлөхүүдэд орлоо.

- Огноо: 2025.03.06
- Зохион байгуулагч: МБҮА ТББ,
- Оролцогчид: МБҮА ТББ, “Дулаан шийдэл II” төслийн зөвлөхүүд
- Хамрагдсан хүний тоо: 22



COORDINATION MEETING

“Дулаан шийдэл II” төслийн хэрэгжүүлэгч 5 байгууллагуудын хооронд зохион байгуулагддаг 14 хоног тутамд хийгдсэн ажил болон ирэх 14 хоногийн хугацаанд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын танилцуулга онлайн уулзалт боллоо.

- **Огноо:** 2025.03.11
- **Зохион байгуулагч:** Жэрэс ОУТББ,
- **Оролцогчид:** Жэрэс ОУТББ, МБҮА ТББ, БЭХХТ, МНСК
- **Хамрагдсан хүний тоо:** 14

"ДУЛААН ШИЙДЭЛ I, II" ТӨСЛИЙГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЖЭРЭС ОУТББ-ЫН УДИРДЛАГУУДТАЙ УУЛЗЛАА



МБҮА ТББ нь агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, барилгын салбарт дулаалгын зах зээл, эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах, салбарын ажиллах хүчнийг чадавхжуулах зэрэг зорилгоор 2018 оноос хойш Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл I, II” төслийг бусад түншлэгчийн хамтаар хэрэгжүүлж байна.

Төслийн үйл ажиллагаа, цаашдын тогтвортой байдлыг хангах, барилгын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар харилцан байр сууриа солилцох зорилгоор МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх өнөөдөр (2025.03.12) Жэрэс ОУТББ-ын Азийн бүс хариуцсан захирал Квентин Морро, тус байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгч Завьер Рат нарыг хүлээн авч уулзав. Уулзалтаар талууд олон жил хамтарч ажиллаж ирсэн туршлагадаа тулгуурлан, цаашид үргэлжлүүлэн үр дүнтэй хамтран ажиллахаа илэрхийллээ.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ДУЛААЛСАН БАЙШИНТАЙ ТАНИЛЦАХ, ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ





Зорилго:

- “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд бүтэн дулаалга хийсэн СХД-ийн 7-р хорооны иргэн У.Насанбатын байшинг танилцуулах замаар дулаалга, эрчим хүч хэмнэлтийн талаар төр, хувийн хэвшил, иргэдэд тайлбарлан таниулах
- Дулаалга хийлгэснээр гарсан үр дүнгийн талаар айл өрхийн байр суурь, сэтгэгдлийг сонсох
- Дулаалгын технологийн талаар Төслийн инженер, гүйцэтгэгчидтэй ярилцах

Зохион байгуулагч: МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төсөл

Зочид, төлөөлөгчид: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, УИХ-ын гишүүн Г.Лувсанжамцын ажлын алба, Жэрэс ОУТББ-ын төлөөллүүд оролцлоо.
Хамрагдсан хүний тоо: 31
Хэзээ: 2025.03.12
Хаана: СХД, 7-р хороо, Баянхошуу, 6-р гудамж, 19 тоот, СХД, 7-р хороо, Баянхошуу, 6-р гудамж, 19 тоот, хувийн сууц, https://maps.app.goo.gl/3aqVNzYT84LWSqLV9

“Дулаалсан байшинтай танилцах, эрчим хүч хэмнэлтийн үр дүнг танилцуулах нээлттэй өдөрлөг” арга хэмжээ-д МБҮА ТББ-ын гишүүн 8 байгууллагын 12 хүнийг хамруулав. Үүнд: БХЯ-ны Барилга захиалагчийн алба, “Бодь Пропертийз” ХХК, “Бульдорс мон” ХХК, “Н Эй Би” ХХК, “Фэйрви” ХХК, “Эрчим инженеринг” ХХК, “Бүти” ХХК, “Дабль пирамид” ХХК

“Дулаалсан байшинтай танилцах, эрчим хүч хэмнэлтийн үр дүнг танилцуулах нээлттэй өдөрлөг”-ийн талаарх мэдээтэй доорх линкээр орж танилцана уу.

https://www.facebook.com/share/v/12JtnESbC1w/

https://time.mn/n/84649


https://www.facebook.com/share/v/18jJXhQFJS/


https://www.facebook.com/share/p/1GhKL7AdYA/


https://www.facebook.com/share/p/18WfDXLZ14/

https://www.facebook.com/share/v/14mt1efRoU/

ЗАСГИЙН ГАЗАРТ ТАНИЛЦУУЛАХ ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТОДОРХОЙ ТОО БАРИМТУУДЫГ ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ-Д ИЛГЭЭЛЭЭ









"Дулаан шийдэл" төслийн хүрээн дэх дулаалгын зах зээлийн тоо баримт

- "Дулаан шийдэл II" төслийн хүрээнд барилга, байшингийн дулаалга хийхэд бэлтгэгдсэн барилгын салбарын ажиллах хүчний тоо: 70 бригадын 210 хүн
- Үүнээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй: 40 бригадын 120 хүн
- 2018 оноос "Дулаан шийдэл" дулаалсан айл өрхийн тоо: 4854
- Цаашид дулаалах боломжтой айл өрхийн тоо: 5900 хүртэл
- 6х7 хэмжээтэй байшинг бүтэн дулаалах дундаж зардал: 20 сая төгрөг
- 6х7 хэмжээтэй байшингийн бүтэн дулаалгын ажлыг гүйцэтгэх хугацаа: 14 хүртэл хоног
- Санхүүжилтийн хэлбэр: Банк, санхүүгийн байгууллагын зээл, айл өрхийн хувийн санхүүжилт, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт гэх мэт


МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА БОЛОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ СВИЧ-ЭШИА ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ “ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙНХЭЭ ДУНД ӨГЛӨӨНИЙ АЖИЛ ХЭРЭГЧ БИЗНЕС УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА


МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болон Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн дулаалгын зөвлөхүүдийнхээ дунд "Өглөөний ажил хэрэгч бизнесийн уулзалт" зохион байгууллаа. Энэхүү уулзалтын зочид болох “Гурван бухат групп” ХХК-ийн ерөнхий захирал Т.Ганчимэг, “Добу технологи” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Тулгабаатар нар бизнес эрхлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалт босгохоос эхлээд гүйцэтгэлдээ анхаарах, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөртөө мэдээллийн технологийн оновчтой шийдлүүд нэвтрүүлэх нь зүйтэй талаар хэлж байв.

“Аливаа асуудал тулгарлаа гэхэд түүнийг бэрхшээл гэж харалгүй, гарц хайдаг. Хэлсэндээ хүрдэг байх нь хамгийн чухал" гэдгийг Т.Ганчимэг онцолж байсан бол “Сүүлийн үеийн технологийн чиг хандлага нь эрүүл амьдралын хэв маягт чиглэж байгаа” талаар Д.Тулгабаатар оролцогчдод мэдээлэл өглөө. Мөн уулзалтаар “Бульдорс Мон ХХК”, “Ультрасоник” ХХК, “Динамик тауэр” ХХК өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ онцлог, давуу талыг танилцуулав.

Огноо: 2025.03.20
Зохион байгуулагч: МБҮА ТББ
Хамрагдсан хүний тоо: 45
“Өглөөний ажил хэрэгч бизнесийн уулзалт” арга хэмжээ-д МБҮА ТББ-ын гишүүн 18 байгууллагын 22 хүнийг хамруулав.












БРИГАДУУДАД ЗОРИУЛСАН ЗӨЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН СУДЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЗӨЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТИЙН СУДАЛГААГ ЯВУУЛЛАА



Энэхүү судалгаа нь Бригадуудад зориулсан зөэлийн бүтээгдэхүүн судлах ажлын хүрээнд орон


сууцны шинэчлэл, засварын салбарт ажиллаж буй барилгын салбарын бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг судалж, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь зориулсан зээлийн шинэ бүтээгдэхүүний эрэлт хэр байгааг судлах зорилготой.

- Хувиараа болон компанитай бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоо, санхүүгийн эх үүсвэр?
- Бизнесээ санхүүжүүлэхдээ авч байсан зээлийн нөхцөл болон мэдээлэл?
- Санхүүгийн дэмжлэг авахад тулгардаг бэрхшээлүүд?
- Ямар төрлийн санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгаа эсэх?
- Эрчим хүчний хэмнэлттэй засварын арга техникт сургах нь бизнесээ өргөжүүлэхэд тустай эсэх талаар 20 асуулт бэлтгэн судалгаа явуулсан.

Хамрагдсан хүний тоо: 39
Судалгаа явуулсан огноо: 2025.03.14-03.21-ний өдрүүдэд

ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭЭС САНАЛ ХҮСЭЛТИЙН СУДАЛГАА АВЛАА

Зорилго: Дулаан шийдэл- II төсөлтэй Барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хамтран ажиллах боломж нөхцөл, төслөөс авч буй үр шим, цаашдын сургалт, арга хэмжээний санал, дулаалга, эрчим хүчний хэмнэлтийн саналууд болон БСБЭ-ээс төслийн үйл ажиллагаанд нэмэлт санал, хүсэлт авах зорилготой.



- Төслөөс зохион байгуулсан, өөрийн оролцсон сургалтууд болон арга хэмжээний агуулга, зохион байгуулалтад үнэлгээ өгөх?
- 2025 онд ямар чиглэлийн сургалт зохион байгуулах?
- Дулаан шийдэл-2 төсөлд бригадуудаас ирүүлэх санал хүсэлт
- Төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд?
- Төслийн хүрээнд тухайн бригадуудаас хэчнээн хүн сургалтад хамрагдсан мөн хэд нь эмэгтэй байсан эсэх?
- Төслийн хүрээнд хамтран ажилласан байгууллага, бригадууд болон орлогын мэдээлэл?
- Дулаалга, эрчим хүч хэмнэлтийн зах зээлийг хэрхэн өргөжүүлэх талаар бригадуудын санал болон маркетингийн арга барилууд гэх мэт нарийвчилсан 22 асуулттай санал хүсэлтийн судалгааг явуулав.

Хамрагдсан хүний тоо: 4


ЕВРОПЫН ХОЛБООНЫ СВИЧ-ЭШИА ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ "ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛИЙН ЧАДАВХЖУУЛАХ БАГЦ ХӨТӨЛБӨРҮҮДЭД УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БАРИЛГЫН САЛБАРЫН ИРГЭН, БРИГАД, БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ДУНД НЭЭЛТТЭЙ ЭЛСЭЛТ ЗАРЛАЛАА

МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн баг нь 2025.03.20-22-ны 14 цаг хүртэл Улаанбаатар хотын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дунд төслийн чадавхжуулах багц хөтөлбөрүүдэд хамруулан чадавхжуулах нээлттэй элсэлтээ зарлаж, бүртгэв. Тус элсэлтийг МБҮА ТББ-ын Дулаан шийдэл- II төсөл, Жэрэс ОУТББ, Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Дулаалгын хялбар шийдэл аян, Монголын Ногоон Санхүүгийн Корпораци зэрэг байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд зарлалаа. Үүний үр дүнд Улаанбаатар хотын 50 орчим барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид бүртгүүлсэн байна.

2025.03.24-03.28-ны хооронд БЭХХТ-д зохион байгуулж буй Барилгын дулаалгын технологи, Дулаан хамгаалалтын үнэлгээ сургалтад 30 гаруй БСБЭ-д хамрагдаж байна. Үүнээс 18 нь Чингэлтэй дүүргийнх бөгөөд Чингэлтэй дүүргийн холбогдох удирдлагууд, мэргэжилтнүүдтэй нягт хамтран ажиллаж байна.







Төслийн чадавхжуулах багц хөтөлбөрүүдэд хамрагдсанаар:

- Хувийн сууц (байшин, амины орон сууц)-ийг технологийн дагуу дулаалах, дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын үнэлгээ гаргах чадварт суралцах
- Дулаалгын зах зээлийн мэдлэг, мэдээлэлтэй болох
- Маркетинг, борлуулалтаа өсгөх, бизнесээ тэлэх санаа шийдлүүдтэй болох
- Барилгын салбарт тулгамдаж буй жендэрийн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар мэдлэгтэй болох
- Барилгын хог хаягдлын менежментийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Бизнесийн харилцаа холбоогоо өргөжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх гэх мэт зэрэг өргөн боломжтой


Төслийн санхүүжүүлэгч:

- Европын холбооны төлөөлөгчийн газар
- Европын холбооны Свич-Эшиа хөтөлбөр
- Олон улсын жендерийн байгууллага
- Францын хөгжлийн агентлаг

Төслийн хэрэгжүүлэгч:

- Жэрэс ОУТББ
- Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ
- Барилгын Эрчим Хүч Хэмнэлтийн Төв
- Монголын Ногоон санхүүгийн корпораци
- Монголын Эмэгтэйчүүдийн Сан

COORDINATION MEETING



“Дулаан шийдэл II” төслийн хэрэгжүүлэгч 5 байгууллагуудын хооронд 14 хоног тутамд хийгдсэн ажил болон ирэх 14 хоногийн хугацаанд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын танилцуулга онлайн уулзалт боллоо.

Огноо: 2025.03.25
Зохион байгуулагч: Жэрэс ОУТББ,
Оролцогчид: Жэрэс ОУТББ, МБҮА ТББ, БЭХХТ, МОНЭС
Хамрагдсан хүний тоо: 9

МБҮА ТББ БОЛОН БРИГАДУУДЫН ЗҮГЭЭС DULAALGA.MN ВЕБ САЙТАД ИЛЭРСЭН АЛДААНЫ ЖАГСААЛТЫГ ГАРГАН ХӨГЖҮҮЛЭГЧ КОМПАНИАР ЗАСВАРЛУУЛАХ АЖИЛ ХИЙГДЭЖ БАЙНА

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2025.03-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ТООН ҮЗҮҮЛЭЛТ
1.	ББЖБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	26
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан ББЖБЭ-ийн тоо	14
3.	ББЖБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	4
4.	ББЖБЭ-дэд зуучилсан дулаалгын ажлын тоо	-
5.	ББЖБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	3
6.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон ББЖБЭ-ийн тоо	22
7.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн ББЖБЭ-ийн тоо	4
8.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагчдын тоо	2
9.	Цахимаар авсан ББЖБЭ-ийн судалгаанд оролцогчдын тоо	80



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn